



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 01 сарын 26 өдөр

Дугаар 25

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, "Мэдээ тайлангийн маягт батлах тухай" 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Үндэсний аудитын газрын харьяа Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын шаардлага хангахгүй, сэргээн засварлах боломжгүй болсон засвар хийхэд эдийн засгийн хувьд ашиггүй 38,300,000.00 /гучин найман сая гурван зуун мянган/ төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий 2 ширхэг автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2.Үндэсний аудитын газрын Тамгын газрын дарга Ц.Ганболд, Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга Х.Түвшинбаяр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулах;

2.2.Дуудлагын худалдааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулах, дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4.Энэ тогтоолын биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримт, автомашиныг улсын бүртгэлээс хасуулсан тодорхойлолтыг 2021 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ


ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



13201011

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн
25... дугаар тогтоолын хавсралт



Үндэсний аудитын газрын харьяа Говь-Алтай аймаг дахь
Төрийн аудитын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нээлттэй
дуудлагын худалдаагаар худалдах автомашины жагсаалт

Д/д	Автомашины марк, улсын дугаар, арал	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Гүйлт, км (мянга)	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Сэргээн босголт (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)
1	Ландкрузер-80, 93-46 ГАА, арал№FZJ800100577	1995/ 2010	1998,3	27,600,000.00	500,000.00	1,000,000.00
2	Истана, 20-05 ГАА, арал№KPDGBDH811P 138852	2001/ 2011	1132,0	10,700,000.00	500,000.00	500,000.00
	Нийт дүн			38,300,000.00 /гучин найман сая гурван зуун мянган/	1,000,000.00	1,500,000.00 / нэг сая таван зуун мянган/